



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

2024.03.26 № А-1/1336  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендер шалгаруулалтын тухай**

Тус газраас 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зарласан ЗТХЯ/20240101116 дугаартай “Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад тусгагдсан төсөл, арга хэмжээний авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ” авах төсөл, арга хэмжээний тендерт оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга авах хүсэлт ирүүлсэнтэй холбогдуулан дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
Авто замын зураг төсөл боловсруулсан байгууллага нь тухайн зураг төсөл дээрээ техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг үзүүлж болох уу?	Зураг, төсөл нь тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт “Тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахад зөвлөгөө өгсөн, оролцсон, эсхүл тухайн зөвлөгөө өгсөн, оролцсон этгээдтэй харилцан хамааралтай...” гэж заасны дагуу авто замын зураг төсөл боловсруулсан байгууллага нь тухайн зураг төсөл дээрээ техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг үзүүлэхээр тендер ирүүлсэн тохиолдолд ерөнхий шаардлага хангаагүй оролцогч гэж үзнэ.
Тус тендерийн баримт бичигт хүлээн авах хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 12 цаг 00 минутад тендер шалгаруулалтын бичиг баримтыг илгээх гэж заасан бол тендер шалгаруулалтын баримт бичгийг өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 26.1 дээр 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 12 цаг 00 минутад тендер шалгаруулалтын бичиг баримтыг хүлээн авахаар оруулсан байна. Аль хугацаанд авах вэ?	Тус газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А-3/1263 дугаартай албан бичгээр тендерийн баримт бичиг дараах өөрчлөлтийг оруулж Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> сайтын тухайн төсөл, арга хэмжээний тодруулга хэсэгт шинэчлэн байршуулсан. Үүнд: ТШЗ 26.1-д Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, Цаг: 12 цаг 00 минут гэж; ТШЗ 26.2-д Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, Цаг: 12 цаг 10 минут гэж;

ДАРГА



Ц.БАТЗУЛ

1324023631

ТХААГ-2024-А4